

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 15 -ны өдөр

№ 07

Улаанбаатар хот

Батлан даалт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 8.6.29 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь өөрийн хамаарал бүхий компани болох “Ниосити долоо” ХХК-ийн “Мбанк” ХК-тай байгуулах Зээлийн гэрээний үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор батлан даалт гаргасугай.
2. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор “Ниосити долоо” ХХК-тай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1-д дурьдсан Баталгааны гэрээнд компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг ТУЗ-ийн дарга /Б.Наранбат/-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 16 -ны өдөр

№ 08

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн “Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Нэгдүгээр хавсралтаар, “Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдэд зориулсан 2026 оны сургалтын төлөвлөгөө”-г Хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, жилийн ажлын гүйцэтгэлийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулах, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ



[illegible]

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны ... сарын
...-ны өдрийн ... тоот Тогтоолын Хавсралт №02



**"СЭНДЛИ" ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД
ЗОРИУЛСАН 2026 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Сургалтын нэр	Хийгдэх хугацаа	Хариуцсан байгууллага, ажилтан	Тайлбар
1	Чиглүүлэх сургалт	Тухай бүр	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	ТУЗ-ийн гишүүд өөрчлөгдөх тохиолдолд шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдэд зориулсан сургалт
2	Удирдах ажилтны сургалт	Улирал бүр	Сэндли ББСБ ХК-ийн сургалт хариуцсан ажилтан	Компанийн хэмжээнд нийт удирдах ажилтнуудад зориулсан
3	Компанийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулах сургалт	6 болон 12 дугаар саруудад	Сэндли ББСБ ХК-ийн сургалт хариуцсан ажилтан	Компанийн үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлж байгаа бүтээгдэхүүн үйлчилгээг таниулах зорилготой.



Send!

[illegible]